



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 12 сарын 02 өдөр

Дугаар А/478

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.1.6 а, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 02/01 дүгээр тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны “Бүтээлч-Өвөрхангай-2020” хөтөлбөрийн 2.9.2-т заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. БНСУ-ын Кенпу, Янжу хотуудад 2019 оны 12 дугаар сарын 7-11-ний өдрүүдэд ажлын албан ёсны айлчлал хийх бүрэлдэхүүнд:

-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга А.Ишдорж

-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч Р.Өлзийжаргал

-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч Б.Батмөнх

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Д.Нэмэхбаяр нарыг оролцуулсугай.

2. Айлчлалын бүрэлдэхүүний зардалд шаардагдах 7.000.000 (долоон сая) төгрөгийг аймгийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх зардлаас зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011101373